



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 106

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол-Солонгосын Политехникийн коллежийн 2019 оны эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч нийт 1.2 сая төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Монгол-Солонгосын Политехникийн коллежийн 2019 оны үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Монгол-Солонгосын Политехникийн коллежийн захирал (Х.Цэгмид)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Барилга болон автомашины ашиглалтын хувийн хэргийг холбогдох журмын дагуу тогтмол хөтөлж, хөрөнгийн өнөөгийн үнэ цэнийг зөв тооцож, бүртгэл хөтлөх;

2.2. Шинээр хөрөнгө олж авах, бэлтгэхдээ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай” журмын дагуу зөвшөөрөл авах;

2.3. Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо Нягтлан бодох бүртгэлийн хууль болон холбогдох журам зааврын дагуу тооцох;

2.4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гарсан тогтоол, шийдвэрийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлэх;

2.5. Ажил үүргээ холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох;

2.6. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

133001361

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2021 оны 4 дугаар сарын 28-ний өдрийн
108 дугаар тогтоолын хавсралт



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал,
түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрх зүйн акт	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай" журмын дагуу зөвшөөрөл аваагүй	Захирал Х.Цэгмид, Ерөнхий нягтлан бодогч П.Пүрэвдорж	1.2	-Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг; - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталж, гаргасан 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журам батлах тухай	-Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; -Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай" мөрдөж ажиллах
Нийт дүн			1.2		